



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
И-мэйл: mofa@mofa.gov.mn; Вэбсайт: www.mofa.gov.mn

2022.11.11 № 01/3569

танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.ГАНИБАЛ ТАНАА

Танаас 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
41 тоот албан бичгээр ирүүлсэн асуулгатай танилцаж,
холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт...⁷... хуудастай.

Хүндэтгэсэн,

Х.БОЛОРЧУЛУУН


00002917

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн Сайдын
2022 оны .11. дүгээр сарын .11.-ны
өдрийн 01/3569 дугаар албан
бичгийн хавсралт

1.Монгол Улс жилд дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаад хэчнээн хэмжээний мал, мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжит нөөцтэй талаар:

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар баталсан жишсэн дундаж нэг хүний хоногт хэрэглэх мах, махан бүтээгдэхүүний хэмжээг үндэслэн тооцоход Монгол Улсын нийт хүн амын хүнсний хэрэгцээнд нийт жилд 120.0 орчин мян.тн мах, махан бүтээгдэхүүн шаардлагатай боловч бодит хэрэглээ үүнээс 2.8 дахин их байна.

Зураг 1. Малын тоо, мян.тол /2012-2021 он/



/Эх үүсвэр:ҮСХ, ХХААХҮЯ-ны тооцоолол/

Монгол Улсын мал сүргийн тоо 2015-2021 онд дунджаар 3.8 хувиар өсөж, 2021 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 67343.4 мянган толгой мал тоолуулсан ба 2022 онд 24.0 сая төл бойжиж байна.

Монгол Улс 67.3 сая толгой мал (2021 оны ҮСГ-ын мэдээлэл)-тай, сүүлийн 5 жилийн дунджаар 20%-ийг (15.0 сая) хүнсэнд хэрэгцээлж, эдийн засгийн эргэлтэд оруулдаг бөгөөд жилд 170.0-180.0 мян.тн махыг экспортлох боломжтой байна.

Аймаг, орон нутгаас ирүүлсэн судалгаагаар 2022 оны өвлийн улиралд нийт 5.6 сая малыг хүнсэнд хэрэгцээлж, 13.7 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулах урьдчилсан тооцоололтой байна.

Хүснэгт 1. Мал, мах бэлтгэлийн урьдчилсан тооцоолол 2022*

№	Малын төрөл	Нийт малын тоо, мян.тол	Нийт бэлтгэх		Хүнсэнд хэрэглэх		Зах зээлийн эргэлтэд оруулах	
			Малын тоо, мян.тол	Мах, тн	Малын тоо, мян.тол	Мах, тн	Малын тоо, мян.тол	Мах, тн
1	Хонь	1,086.7	9,533.6	190,672.0	2,708.5	54,170.0	6,825.1	136,502.0
2	Ямаа	26,456.0	7,977.9	127,646.4	2,390.0	38,240.0	5,587.9	89,406.4
3	Адуу	4,324.5	736.1	110,415.0	207.0	31,050.0	529.1	79,365.0
4	Үхэр	5,022.2	1,050.9	136,617.0	329.4	42,822.0	721.5	93,795.0
5	Тэмээ	454.0	46.4	8,352.0	14.2	2,556.0	32.2	5,796.0
	НИЙТ	67,343.4	19,344.9	573,702.4	5,649.1	168,838.0	13,695.8	404,864.4

Экспортлох махны боломжит нөөц нь малын тоо толгойн өсөлт болон хүн амын хүнсний хэрэглээтэй шууд холбоотой. Иймд зах зээлийн эргэлтэд оруулах хонины махны 70 хувийг, ямааны махны 30 хувийг, үхрийн махны 80 хувийг, адууны махны 20 хувийг, тэмээний махыг бүрэн хот, суурин газрын хүн амын 2022-2023 оны өвөл, хаврын улирлын махны хэрэгцээнд /нийт 387.9 мян.тн/ бэлтгэн нийлүүлнэ гэж тооцоолон, экспортын боломжит нөөцийг тооцов.

Хүснэгт 2. Хүнсэнд 2022* онд хэрэглэх малын мах, экспортын нөөц, төсөөлөл

№	Малын төрөл	Нийт малын тоо	Нийт бэлтгэх		Үүнээс			
					Дотоодын хэрэглээнд		Экспортын боломжит нөөц	
			Малын тоо, мян.тол	Мах, тн	Малын тоо, мян.тол	Мах, тн	Малын тоо, мян.тол	Мах, тн
1	Хонь	31,086.7	9,533.6	190,672.0	7,486.1	149,721.4	2,047.5	40,950.6
2	Ямаа	26,456.0	7,977.9	127,646.4	4,066.4	65,061.9	3,911.5	62,584.5
3	Адуу	4,324.5	736.1	110,415.0	312.8	46,923.0	423.3	63,492.0
4	Үхэр	5,022.2	1,050.9	136,617.0	906.6	117,858.0	144.3	18,759.0
5	Тэмээ	454.0	46.4	8,352.0	46.4	8,352.0	-	-
	НИЙТ	67,343.4	19,344.9	573,702.4	12,818.3	387,916.3	6,526.6	185,786.1

/*ХХААХҮЯ-ны урьдчилсан тооцоолол/

Дээрх тооцооллоос харахад Монгол Улс 2022* онд 6526.6 мянган толгой мал буюу 185.8 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжит нөөцтэй байна.


2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3-т “Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.” Хэмээн заасан байдаг. Тус заалтын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар өнгөрсөн хугацаанд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлын талаар:

Монгол Улсын 2018 онд 70.4 мян.тн, 2019 онд 58.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон ба Дэлхийн нийтийн хамарсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас дээрх тоо хэмжээ 45% буурч 2020 онд 38.8 мян.тн, 2021 онд 21.8 мян.тн, 2022 оны 10 сарын байдлаар 6.1 мян.тн мах, махан бүтээгдэхүүн тус тус экспортолсон байна.

Хүснэгт 3. Мах, махан бүтээгдэхүүний экспортын гүйцэтгэл, мян.тн

№	Махны нэр төрөл	2017	2018	2019	2020	2021	2022.10
1	Адууны түүхий мах	26.1	32.2	30.8	17.6	7.0	2.7
2	Үхрийн түүхий мах	0.6	1.1	-	1.8	-	-
3	Хонь, ямааны түүхий мах	2.6	6.2	7.0	1.8	0.9	3.2
4	Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах	2.8	29.3	18.4	19.4	13.4	
5	Дайвар бүтээгдэхүүн	0.1	1.6	2.4	1.2	0.5	0.2
	Нийт	32.2	70.4	58.6	41.8	21.8	6.1

Зураг 2. Мах, махан бүтээгдэхүүний экспортын гүйцэтгэл, мян.тн



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас шалтгаалан 2020, 2021 онд БНХАУ Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн импортлохыг тодорхойгүй хугацаагаар зогсоох шийдвэр гаргасан нь мах, махан бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ өмнөх онуудтай харьцуулахад 35-45 хувь буурах үндэслэл болсон ба 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс хойш Эрээн боомтоор мах, махан бүтээгдэхүүн экспортлоогүй байна.

Монгол Улсын Гадаад харилцааны яам БНХАУ-ын эрх бүхий байгууллагатай олон удаагийн яриа, хэлцэл хийсний дүнд Эрээн хотын Ардын Засгийн газрын Гадаад хэрэг эрхлэх хэлтсээс 05 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн 83/2022 ноот бичигт “хүйтэн хэлхээний махан бүтээгдэхүүний импортыг сэргээж, эхний ээлжид дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах импортлох, импорт тогтворжсоны дараа адууны хөлдөөсөн махны импортыг эхлүүлэх тухай” мэдэгдэж, цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар тавигдах шаардлагыг ирүүлсэн.

Иймд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/12 дугаар тушаалын хүрээнд БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүн экспортыг сэргээх ажлыг эрчимжүүлж, ажлын хэсгийн төлөвлөгөөг батлан ажиллаж, БНХАУ-ын эрх бүхий байгууллагын импортын мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, баталгаажуулах талаар тавьсан шаардлагыг бүрэн хангаж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газартай “Нэмэлт гэрчилгээ”-ний загварыг тохирсон.

Хүнсний тухай хууль, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлагдсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу Монгол Улсын мал сүргийн өсөлт, 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсаас экспортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээний талаарх саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд хонь, ямааны түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах, адууны түүхий маханд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлүүлсэн. Харин үхрийн түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдад зөвлөмж болгосон тул дээрх махны экспортын зөвшөөрөл олгох ажлыг “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлээр дулааны аргаар боловсруулсан махны үйлдвэрлэл, экспортыг түр түдгэлзүүлж, мал төхөөрөх, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа, эрүүл ахуй, чанар, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийхээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 86 дугаар захирамж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/03, 01/82, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 01/501, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын хамтарсан удирдамжийн хүрээнд зохион байгуулсан хяналт, шалгалтаар чанар, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан нь тогтоогдсон аж ахуйн нэгжийн дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн экспортлохоор зохион байгуулалтын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн. Гэвч БНХАУ-ын Эрээн боомтын Коронавируст халдварын нөхцөл байдлаар шалтгаалан Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн импортлох асуудлыг хойшлуулсан ба БНХАУ-ын Гаалийн ерөнхий газраас 2022 оны 10 дугаар сарын 26-

ны өдөр ирүүлсэн албан бичигт 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Эрээн боомтоор мах, махан бүтээгдэхүүн импортлох болсныг мэдэгдсэн.

БНХАУ-тай хүнсний аюулгүй байдал, тээвэрлэлтийг хэрхэн зохион байгуулах талаар Гадаад харилцааны яамтай хамтран импортлогч талтай тохиролцож байгаа боловч тооны хязгаарлалттайгаар хил нэвтрэх, энэ нь мах, махан бүтээгдэхүүний экспортод хүлээлт үүсгэж байна.

Монгол Улс, БНХАУ хооронд байгуулсан хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын протоколд нийцүүлэх замаар экспортын эрхтэй үйлдвэрийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх саналыг 2021 онд Гадаад харилцааны яамаар дамжуулан БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Цаашид мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхээр гуравдагч орны зах зээлд шинээр нэвтрэх, тэр дундаа Ойрх Дорнод болон Зүүн өмнөд азийн улсуудад халал аргаар бэлтгэсэн мах экспортлох нөхцөлийг бүрдүүлэх, мал эмнэлэг, хорио цээрийн шаардлага, нөхцөл тохирох чиглэлээр хамтран зарим улсуудтай хамтран ажиллаж байна.

Монгол Улс мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөл, шаардлага тохиролцох чиглэлээр 16 улс оронтой хамтран ажиллах гэрээ, Засгийн газар хоорондын 2 хэлэлцээрийг байгуулсан байна. Мөн мал эмнэлгийн гэрчилгээ 36, мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл 9, хорио цээр, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлага 3-ыг тус тус тохиролцсон.

Мөн махны өртгийн сүлжээнд оролцож буй малчид, мал төхөөрөх үйлдвэрийг халал үйлдвэрлэлийн арга технологид сургаж, баталгаажуулалтыг олон улсын жишгийн дагуу явуулснаар халал мах экспортлох нөхцөл бүрдэж, экспортын орлогыг 2- 4.5 дахин нэмэгдэх боломжтой юм.

3. Тогтоолын 3.3.12-т “Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.” Гэж заасан. Энэ хүрээнд мах, махан бүтээгдэхүүн импортлогч орнуудтай хатуу гэрээ хэлцэл хийх, тээвэрлэлт, логистикийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр авч хэрэгжүүлж буй болон төлөвлөж буй арга хэмжээний талаар:

№	Төрөл	Нэр	Батлагдсан огноо
1. Оросын Холбооны Улс			
1	Хэлэлцээр	1. Мал, амьтан, түүний гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд тэжээлийг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх үед баримтлах мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөл болон хил орчмын районд хэрэгжүүлэх хамтарсан арга хэмжээний тухай Монгол Улсын ХХААЯ-ны мал эмнэлгийн албаны ерөнхий газар, ОХУ-ын ХАА, Хүнсний яамны мал эмнэлгийн Департаментын хоорондын хэлэлцээр	5/13/1994
2		2. Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	4/11/2008

3	Протокол	1. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг-Мал эмнэлгийн ерөнхий газар болон Оросын Холбооны Улсын Мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын албаны төлөөлөгчдийн уулзалтын протокол	5/31/2019
4		1. Veterinary certificate for breeding and commercial sheep and goats exported to the customs territory of the Eurasian Economic Union Монгол Улсад экспортлох үржлийн болон хэрэглээний хонь, ямааны мал эмнэлгийн гэрчилгээ	12/8/2015
5		2. Veterinary certificate for cattle embryos exported to the customs territory of the Eurasian Economic Union	12/8/2015
6	Гэрчилгээ	4. Veterinary certificate for hides, horn and hoof, intestines, furs, sheep pelt, lambskin, wool, goat down hair, bristle, horsehair, and chicken, duck, goose and other poultry feathers and down feathers exported to the customs territory of the Eurasian Economic Union	5/21/2020
8		6. Veterinary certificate for canned meat products, sausage and other processed meat products exported from the Russian Federation to Mongolia	5/26/2020
9		7. Монгол Улсаас ОХУ болон Беларусь, Казахстан Улсад экспортлох үхрийн мах, дайвар бүтээгдэхүүний гэрчилгээ	5/16/2019
10		8. Монгол Улсаас ОХУ болон Беларусь, Казахстан Улсад экспортлох адууны мах, дайвар бүтээгдэхүүний гэрчилгээ	5/16/2019
11	Гэрээ	1. Contract between Federal State Financed Institution "Federal Centre for Animal Health" (FGBI "ARRIAH") and General Authority for Veterinary Services (GAVS) of the Government of Mongolia	7/8/2019
2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс			
1		1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд мал, амьтны хорио цээр болон мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр	4/29/1994
2	Хэлэлцээр	2. Хүнсний бүтээгдэхүүний импорт, экспортын аюулгүй байдлын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ХХААХҮЯ болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хоорондын хэлэлцээр	4/17/2009
3		1. Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуйн яам, БНХАУ-ын чанар, хорио цээрийн хяналт, шалгалтын ерөнхий газрын хооронд БНХАУ-аас Монгол Улсад гахайн мах/өөх экспортлох хорио цээр, ариун цэврийн шаардлагын талаар байгуулсан протокол	7/6/2001
4	Протокол	2. Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуйн яам, БНХАУ-ын чанар, хорио цээрийн хяналт, шалгалтын ерөнхий газрын хооронд БНХАУ-д адууны мах экспортлохтой холбогдсон хяналт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протокол	5/24/2005
5		3. Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуйн яам, БНХАУ-ын чанар, хорио цээрийн хяналт, шалгалтын ерөнхий газрын хооронд БНХАУ-аас Монгол Улсад үржлийн үхэр экспортлохтой холбогдсон хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протокол	6/19/2008

6		4. Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийн тухай Монгол Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БНХАУ-ын чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хоорондын протокол	10/27/2011
7		5. Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон БНХАУ-ын чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд Монгол Улсаас БНХАУ-д экспортлох хонь, ямааны махны хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай протокол	8/29/2016
8		6. Монгол улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон БНХАУ-ын чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн махны хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай протокол	8/29/2016
9		7. Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуйн яам, БНХАУ-ын чанар, хорио цээрийн хяналт, шалгалтын ерөнхий газрын хооронд БНХАУ-аас Монгол Улсад үхрийн мах/махан бүтээгдэхүүн экспортлох хорио цээр, ариун цэврийн шаардлагын талаар байгуулсан протокол	7/6/2001
10		8. Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуйн яам болон БНХАУ-ын чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд БНХАУ-д ноос, хонь, ямааны арьс, үхэр, адууны шир экспортлохтой холбогдсон хорио цээр, ариун цэврийн шаардлагын тухай протокол	5/24/2005
11		9. Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам болон БНХАУ-ын чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд БНХАУ-аас Монгол Улсад үхрийн хөлдөөсөн үр экспортлохтой холбогдсон хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протокол	6/19/2008
12		12. Монгол Улсаас БНХАУ-руу нядалгааны зориулалттай хонь болон ямаа импортлох тухай Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон БНХАУ-ын чанарын удирдлага, хяналт, хорио цээрийн ерөнхий газар хооронд байгуулсан протокол	2018
13	Санамж бичиг	1. Вакцинжуулалт хийгдсэн, шүлхийгүй бүсэд тавигдах шаардлагын тухай Монгол Улсын МХЕГ болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	9/18/2018
14		1. Монгол Улсад БНХАУ-аас үржлийн гахай экспортлох мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл	10/25/1995
15		2. Монгол Улсад БНХАУ-аас тэжээвэр шувуу, үржлийн өндөг экспортлох мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл	10/25/1995
16	Нөхцөл	3. БНХАУ-д Монгол Улсаас нядалгааны зориулалтын хонь, ямаа оруулахад халдвараас сэргийлэх ариун цэврийн нөхцөл	10/25/1995
17		4. БНХАУ-д Монгол Улсаас нядалгааны зориулалтын үхэр экспортлох мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл	10/25/1995
18	Гэрчилгээ	1. Монгол Улсаас БНХАУ-д экспортлох адууны маханд олгох мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээ	2010

3. Бүгд Найрамдах Казахстан Улс			
1	Хэлэлцээр	1. Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	3/12/1998
2		2. Мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд, тэжээлийг экспортлох, дамжин өнгөрүүлэхэд баримтлах мал эмнэлэг-ариун цэврийн нөхцөл болон хамтарсан арга хэмжээний тухай Монгол Улсын ХАА-н газрын Мал эмнэлгийн алба, Бүгд Найрамдах Казахстан Улсын ХААЯ-ны Мал эмнэлгийн хорооны хоорондын хэлэлцээр	7/21/1998
3	Протокол	1. Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлгийн ерөнхий газар болон БНКаЗУ-ын мал эмнэлгийн хяналт, тандалтын хорооны төлөөлөгчдийн уулзалтын протокол	5/11/2019
4	Гэрчилгээ	1. Veterinary certificate for bovine semen exported from the Republic of Kazakhstan to Mongolia	2019
5		2. Veterinary certificate for export chicken egg from the Republic of Kazakhstan to Mongolia	2019
6		3. Veterinary certificate for export live cattle from the Republic of Kazakhstan to Mongolia	2019
7		4. Veterinary certificate for export chicken meat from the Republic of Kazakhstan to Mongolia	2019
4. Бүгд Найрамдах Узбекистан Улс			
1	Хэлэлцээр	1. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар болон Бүгд Найрамдах Узбекистан Улсын Мал эмнэлэг, мал аж ахуйн хөгжлийн хороо хоорондын Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр	6/21/2019
2	Гэрчилгээ	1. Veterinary certificate for mutton and goat meat exported from Mongolia to Republic of Uzbekistan	2019
3		2. Veterinary certificate for live sheep and goats exported from Mongolia to Republic of Uzbekistan	2019
4		3. Veterinary certificate for horse meat exported from Mongolia to Republic of Uzbekistan	2019
5		4. Veterinary certificate for beef exported from Mongolia to Republic of Uzbekistan	2019
5. Украин Улс			
1	Хэлэлцээр	1. Монгол Улсын ХХААЯ, Украин Улсын ХАА, үйлдвэрийн бодлогын яам хооронд мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр	4/13/2005
6. Бүгд Найрамдах Беларусь Улс			
1	Санамж бичиг	Монгол Улсын Үйлдвэр, Хөдөө аж ахуйн яам, Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөдөө аж ахуй, хүнсний яам хооронд Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг	2013/09
2	Гэрчилгээ	Veterinary certificate for poultry meat and meat products thereof exported from the Republic of Belarus to Mongolia	2021/10
3		Veterinary certificate for live cattle exported from the Republic of Belarus to Mongolia	2021/10
4		Veterinary certificate for canned food, sausages and other types of ready-to-eat meat products exported to the customs territory of the Eurasian Economic Union	2021/10

5		Veterinary certificate for meat, raw meat materials and offal derived from slaughtered and processed horses exported to the customs territory of the Eurasian Economic Union	2021/10
6		Veterinary certificate for sheep meat and goat meat and raw meat materials and offal derived from slaughtered and processed sheep and goats exported to the customs territory of the Eurasian Economic Union	2021/10
7. Бүгд Найрамдах Аргентин Улс			
1	Санамж бичиг	1. Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын үйлдвэр хөдөө аж, ахуй, мал аж ахуй, загасны аж ахуйн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2014
8. Бүгд Найрамдах Парагвай Улс			
1	Санамж бичиг	1. Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Бүгд Найрамдах Парагвай Улсын Мал аж ахуй, хөдөө аж ахуйн яам хоорондын харилцан ойлгодох санамж бичиг	11/29/2006
9. Арабын Бүгд Найрамдах Египет Улс			
1	Санамж бичиг	1. Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг	5/15/2006
10. Кувейт Улс			
1	Хэлэлцээр	1. Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1/4/2011
11. Исламын Бүгд Найрамдах Иран Улс			
1		1. Health Requirements for fresh chilled vacuum-packed meat from Mongolia	
2	Шаардлага	2. Монгол Улсаас Иран Улсад хонины хөлдөөсөн болон сэрвээсэн мах экспортлох үеийн хорио цээр, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлага.	2011/10
3	Гэрчилгээ	1. Veterinary health certificate for export frozen poultry from Iran	5/27/2020
12. Катар Улс			
1	Хэлэлцээр	1. Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хооронд Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг	11/29/2007
13. Бүгд Найрамдах Турк Улс			
1	Хэлэлцээр	1. Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	3/16/1998
14. Бүгд Найрамдах Тажикистан Улс			
1	Хэлэлцээр	1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Тажикистан Улсын Засгийн газар хоорондын мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр	3/27/2009
15. Бүгд Найрамдах Чех Улс			

1	Гэрчилгээ	3. Veterinary certificate for breeding cattle exported from the Czech Republic to Mongolia (Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол руу экспортолж буй үржлийн үхрийн мал эмнэлгийн гэрчилгээ)	2019/08
16. Бүгд Найрамдах Франц Улс			
1	Гэрчилгээ	1. Health certificate for the export of sheep or goats for breeding from France to Mongolia (Франц Улсаас Монгол Улсад экспортлох үржлийн хонь ямааны мал эмнэлгийн гэрчилгээ)	2013/03
2		2. Health certificate for the export of breeding cattle to Mongolia (Франц Улсаас Монгол Улсад экспортлох үржлийн үхрийн мал эмнэлгийн гэрчилгээ)	2012/02
17. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс			
1	Протокол	1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан –Солонгос– Ард–Улсын– Засгийн–газар–хооронд малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал, амьтны хорио цээр болон мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр	1995/06
18. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс			
1	Хэлэлцээр	1. Мал амьтны хорио цээр, мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНАВьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	10/24/2001
2	Протокол	1. Protocol between the Ministry of Food, Agriculture and Light Industry of Mongolia and the Ministry of Agriculture and Rural Development of the Socialist Republic of Vietnam on Inspection, quarantine and veterinary sanitary requirements with respect to heat-processed meat products derived from cloven-hoofed animals to be exported from Mongolia to Vietnam	12/14/2010
3		2. Protocol between the Ministry of Food, Agriculture and Light Industry of Mongolia and the Ministry of Agriculture and Rural Development of the Socialist Republic of Vietnam on Inspection, quarantine and veterinary sanitary requirements of fresh frozen mutton and goat meat exported from Mongolia to Vietnam	12/14/2010
19. Бүгд Найрамдах Ардчилсан Лоас Ард Улс			
1	Хэлэлцээр	1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лоас Ард Улсын Засгийн газрын хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр	1/24/2005
20. Бүгд Найрамдах Индонез Улс			
1	Санамж бичиг	1. Memorandum of understanding between the Government of Mongolia and the Government of the Republic of Indonesia on cooperation in animal health and quarantine service	10/7/2002
21. Америкийн Нэгдсэн Улс			
1	Гэрчилгээ	1. Health certificate for export of ovine semen from the United States to Mongolia	2000/01
2		2. Health certificate for export of ovine embryos from the United States to Mongolia	2001/01
3		3. Certificate for export requirements for bovine semen exported from the United States to Mongolia	1999/03

4. globalproductprices.com сайтад мэдээлснээр, 2022 онд үхрийн мах олон улсын зах зээл дээр 61.6-3.74 ам.долларын үнэтэй худалдаалагдаж байна. Гэтэл хамгийн эрүүл, органик тэжээлтэй монгол үхрийн мах олон улсын зах зээл дээр хамгийн бага буюу 3.01-2.5 ам.доллаароор худалдаалагдаж ирсэн. Иймд Засгийн газар мах, махан бүтээгдэхүүний үнийг барих асуудлыг зогсоох, цаашилбал экспортод гаргах мал, махны үнийг өсгөх чиглэлээр ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа талаар:

Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох, импортлоход Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын Газрын амьтны эрүүл мэндийн кодексыг баримталдаг.

Газрын амьтны эрүүл мэндийн кодексын зөвлөмжийг хэрэгжүүлснээр мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын худалдааны аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ экспортлогч нь олон улсын худалдааны хоригт өвчингүй, түүнээс сэргийлэх вакцингүй, эрүүл мал болон малын гаралтай бүтээгдэхүүнийг худалдаалахыг заасан байдаг.

Монгол Улсад мал, малын гаралтай бүтээгдэхүүний олон улсын хоригт мал амьтны шүлхий өвчин 2000, 2003, 2004, 2006, 2010, 2013, 2015, 2016, 2017, 2021, хонины цэцэг өвчин 2015-2017, 2021, бог малын мялзан өвчин 2016, 2017 онуудад гарсан нь мал, малын гаралтай бүтээгдэхүүн экспортлох боломж, нөхцөлийг хаасаар байна.

Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс 2016 оноос хойш үхрийн түүхий мах экспортлох тоо хэмжээг тогтоож өгсөн боловч, дээрх олон улсын хоригт өвчний дэгдэлтээс шалтгаалан импортлогч улсад Монгол үхрийн махны үнэ цэнэ буурч, сүүлийн 5 жилийн дунджаар жилд 0.8 мян.тн үхрийн түүхий мах экспортолсон байна.

Иймд Монгол улсад олон улсын худалдааны хоригт өвчин байгаа боловч тодорхой бүс нутагт халдваргүй эрүүл бүсийг бий болгож малын гаралтай мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлэхийн тул "Малын гоц халдварт өвчингүй хорио цээрийн тусгаарлагдсан бүс"-ийг 3 бүсэд байгуулахаар бодлогын баримт бичигт тусган ажиллаж байна.

Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2021 оны А/222, 2022 оны А/294 дүгээр тушаалаар мах, махан бүтээгдэхүүний үйл ажиллагааг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэх, Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан экспортлох боломж нөхцөлийг судалж, цахим системд шилжүүлэхээр ажиллаж байна.

5. Нийт мах, махан бүтээгдэхүүний экспортын 80 орчим хувийг адууны мах дангаараа эзэлдэг. Цаашид олон улсын зах зээл дээр илүү эрэлттэй бөгөөд үнэ хүрдэг үхэр, хонь, ямааны махны экспортыг нэмэгдүүлж чадвал экспортын орлого, үр өгөөжийг нэмэгдүүлэхээс гадна сүргийн бүтцийн зохист харьцааг хадгалж, бэлчээрийн даацад эергээр нөлөөлөх боломжтой. Засгийн газар энэ чиглэлээр ямар бодлого баримталж байгаа талаар тус тус дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэн ирүүлнэ үү.

Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний экспортын 90 гаруй хувийг БНХАУ, үлдсэн хувийг Иран, Арабын нэгдсэн Эмират Улс болон Хонконг эзэлж байна.

ОХУ болон Украин Улсын нөхцөл байдлаас улбаалан 2022 оны 07 дугаар сараас эхлэн ОХУ, Казахстан, Узбекистан зэрэг улсууд Монгол Улсаас үхэр, хонь, адууны түүхий мах импортлох хүсэлтийг ирүүлж, 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт 2.7 мян.тн адууны махыг экспортолсон байна.

Хүснэгт 3. Мах, махан бүтээгдэхүүн экспортын гүйцэтгэл, орноор

Экспортолсон улс		Экспортын эзлэх хувь, %
Хонь, ямааны мах /нийт экспортын 6%/		
1	Арабын Нэгдсэн Эмират Улс	1.2
2	Вьетнам	7.4
3	Иран (Исламын Бүгд Найрамдах)	25.9
4	Хонконг	59.9
Адууны мах /нийт экспортын 35%/		
1	БНХАУ	98.6
2	Казахстан	1.4
Дулааны аргаар боловсруулсан мах /нийт экспортын 59%/		
1	БНХАУ	100

/Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар, 2021 он/

Дэлхийн худалдааны байгууллагын ариун цэвэр, ургамлын ариун цэврийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт холбогдох Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын журмын дагуу Монгол Улсаас БНХАУ болон ОХУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгжид импортлогч улсаас эрсдэлийн шинжилгээ хийж, шаардлага хангасан үйлдвэр, аж ахуйн нэгжийг тухайн улсын эрх бүхий байгууллагын цахим системд бүргэсний дараа тухайн улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх үүсдэг.


Монгол Улсаас ОХУ /евро азийн орон/-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох бүртгэлтэй үхрийн мах экспортлох 31, адууны мах экспортлох 30, дулааны аргаар боловсруулсан бэлэн бүтээгдэхүүн /лаазалсан мах/ экспортлох 10 аж ахуйн нэгж байна.

БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох бүртгэлтэй дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортлох-19 /4 аж ахуйн нэгжийн эрхийг түр түдгэлзүүлсэн/, төхөөрөх 10, адууны мах экспортлох- 9 /1 аж ахуйн нэгжийн эрхийг түр түдгэлзүүлсэн/, Монгол Улсын эрүүл бүс болох Баруун 5 аймгаас /Увс, Завхан, Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай/ үхэр, хонь, ямааны түүхий мах экспортлох эрхтэй 6 аж ахуйн нэгж байна.

Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн “2022-2023 оны өвөл, хаврын бэлчээрийн даацын тодорхойлсон дүн”-гээр нутгийн 60 гаруй хувьд бэлчээрийн даац хэтэрсэн бөгөөд 11 аймагт /Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Баянхонгор, Архангай, Өвөрхангай/ өвөлжилт, хаваржилт хүндрэх эрсдэлтэй байгаа тул Ус цаг уур, орчны удалгаа, мэдээллийн хүрээлэнгээс дээрх аймгууд өвс хадлан, нэмэгдэл тэжээл нөөцлөх, отор нүүдэл хийх, малаа борлуулах, тоог бууруулах зэрэг арга хэмжээ авах, өвөлжилт хаваржилтад эртнээс бэлтгэхийг зөвлөсөн.

Өвөлжилт, хаваржилт хүндрэх эрсдэлтэй дээрх 11 аймгаас урьдчилсан байдлаар 3.2 сая толгой малыг хүнсэнд хэрэглэж, 6.8 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, 41.0 сая толгой мал өвөлжихөөр байна.

Зураг 3. 2022-2023 онд өвөлжилт, хаваржилт хүндрэх эрсдэлтэй аймгууд



Иймд Монгол Улсын Хүнсний тухай хууль, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлагдсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу мал сүргийн өсөлт, 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлыг харгалзан манай улсаас экспортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээний талаарх саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд хонь, ямааны түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах, адууны түүхий маханд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлүүлсэн.

.....ооо.....